

ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Хэнтий аймгийн Хэрлэн сумын Өндөрхаан тохижилтын газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: ХЭА-2022/186/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:
www.audit.mn

Чингис хот
2022 он

Дарга, тэргүүлэх аудитор: Ч.Эрдэнэбаатар
Утас: 70562112

Аудитын менежер: Д.Оюунтуяа
Утас: 99775390

Аудитор: Б.Хуланхатан
Утас: 99008827

Цахим хаяг: khentii@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

1.Төрийн АУДИТЫН САНАЛ, ДҮГНЭЛТ	3
2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	5
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	5
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	6
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	7
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	8
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	9
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан	10
3. Аудитын тайлан	11
3.1 Ерөнхий зүйл	11
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт	11
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	11
3.4 Материаллаг байдал	12
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга	12
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв	13
3.7 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	14
3.7.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	14
3.8 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	14
3.9 Дараагийн аудитаар анхаарах асуудал	14
4. Аудитын илрүүлэлт	14
4.1. Залруулсан алдаа	14
4.2. Зөвлөмж	15
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл	16
Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	16
6. Аудитын тайлангийн хавсралт	17
6.1. Төлбөрийн акт	17
6.2. Албан шаардлага	18

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ОНХС	Орон нутгийн хөгжлийн сан
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт



ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

23119 Хэнтий аймаг, Хэрлэн сум, Сариг баг
Утас: 70-56-21-47, Факс: 70-56-21-12
E-mail: khentii@audit.gov.mn

2022.03.22 № 270

танай _____ -ны № _____ -т

Аудитын санал дүгнэлт гаргах тухай

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Хэнтий аймгийн Хэрлэн сумын Өндөрхаан тохижилтын газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан алдаа, зөрчлийн үр нөлөөг эс тооцвол Хэрлэн сумын Өндөрхаан тохижилтын газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторовын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторовын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Батлагдсан төсвийн зарцуулагдаагүй үлдэгдэл 52.3 сая төгрөгийг холбогдох дансанд төвлөрүүлээгүй нь Төсвийн тухай хуулийн 43 дугаар зүйл. 43.5-д "Төсвийн захирагч нь энэ хуулийн 43.1.3, 43.1.5-д зааснаас бусад төсвийг хоёр төсвийн жил дамжуулан зарцуулахгүй", Засгийн газрын 2015 оны 24 дүгээр тогтоолын хавсралт "Төрийн сангийн үйл ажиллагааны журам" -ын 8.13.3 -д "Төсвийн байгууллагын зарцуулаагүй дансны үлдэгдлийг Төв төрийн сангаас хүргүүлсэн удирдамжийн дагуу татан төвлөрүүлнэ" гэсэн заалттай нийцэхгүй эрх ба үүрэг батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ч.ЭРДЭНЭБААТАР

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Тайланг хугацаа:2021.12.31

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	37,467,114.00	105,172,441.00
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	-	52,294,233.00
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	-	52,294,233.00
3121	Төгрөг	-	52,294,233.00
31211	Төрийн сангийн харилцах	-	52,294,233.00
33	АВЛАГА	117,674.00	-
33200	Төлбөртэй үйлчилгээний авлага	117,674.00	-
35	БАРАА МАТЕРИАЛ	37,349,440.00	52,878,208.00
35200	Дуусаагүй үйлдвэрлэл	10,000,000.00	-
354	Хангамжийн материал	27,349,440.00	52,878,208.00
35410	Бичиг хэргийн материал	121,000.00	417,000.00
35420	Аж ахуйн материал	17,767,590.00	31,256,308.00
35430	Сэлбэг хэрэгсэл	7,865,650.00	8,382,900.00
35440	Түлц, шатах тослох материал	-	45,000.00
35450	Барилгын засварын материал	1,595,200.00	12,777,000.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	8,816,176,919.64	10,384,744,992.49
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	8,816,176,919.64	10,384,744,992.49
392	Биет хөрөнгө	8,586,176,919.64	10,154,744,992.49
39201	Барилга, байгууламж, орон сууц	9,752,404,549.92	12,414,393,850.92
39202	Хуримтлагдсан элэгдэл	(2,742,715,333.89)	(3,753,996,177.05)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	1,591,414,764.00	1,603,914,764.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(517,246,482.74)	(658,075,026.47)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	119,460,942.00	121,315,942.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	(102,428,498.25)	(114,517,858.99)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	18,214,420.76	18,214,420.76
39208	Хуримтлагдсан элэгдэл	(12,014,565.16)	(13,592,045.68)
39213	Түүх соёл, музейн дурсгалт зүйлс	479,087,123.00	479,087,123.00
39214	Бусад үндсэн хөрөнгө	-	58,000,000.00
393	Биет бус хөрөнгө	230,000,000.00	230,000,000.00
39301	Програм хангамж	340,000.00	340,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(340,000.00)	(340,000.00)
39303	Бусад биет бус хөрөнгө	230,000,000.00	230,000,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	8,853,644,033.64	10,489,917,433.49
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	18,374,668.00	-
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	18,374,668.00	-
413	Өглөг	18,374,668.00	-
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	306,866.00	-
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	2,539,146.00	-
4136	Бусад өглөг	15,528,656.00	-
41361	Байгууллагад төлөх өглөг	15,528,656.00	-
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	8,835,269,365.64	10,489,917,433.49
51	Засгийн газрын хувь оролцоо	8,835,269,365.64	10,489,917,433.49
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	4,362,183,848.38	4,362,183,848.38
512	Хуримтлагдсан үр дүн	2,550,454,069.71	4,205,102,137.56
51210	Өмнөх үеийн үр дүн	2,550,454,069.71	2,550,454,069.71
51220	Тайланг үеийн үр дүн	-	1,654,648,067.85
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	1,922,631,447.55	1,922,631,447.55
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	8,853,644,033.64	10,489,917,433.49

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Тайланг хугацаа: 2021.12.31

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэ	/Төгрөгөөр/ Тайланг оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (1)	3,285,857,123.00	3,911,174,481.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	2,316,180,505.00	2,696,667,551.00
120	Нийтлэг татварын бус орлого		
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	2,316,180,505.00	2,696,667,551.00
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого /үндсэн хөрөнгө/		2317 2,692,289,301.00
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого /бараа материал/	2,316,180,505.00	CHOA0046 943,782,500.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	969,676,618.00	1,214,506,930.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс		
131008	Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас санхүүжих	158,311,900.00	437,253,300.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого		
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	48,489,618.00	25,574,230.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон	12,000,000.00	7,000,000.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих		
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	36,489,618.00	18,574,230.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	1,818,113,733.63	2,256,526,413.15
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,818,113,733.63	2,256,526,413.15
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,816,730,733.63	2,228,502,276.15
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	3,559,600.00	-
210102	Нэмэгдэл	3,559,600.00	-
2104	Хангамж, бараа материалын зардал	934,000.00	-
210402	Тээвэр, шатахуун	934,000.00	-
2105	Нормативт зардал	6,120,000.00	-
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	6,120,000.00	-
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	33,984,900.00	621,600.00
210604	Урсгал засвар	33,984,900.00	621,600.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	841,482,491.00	1,032,304,448.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	841,482,491.00	1,032,304,448.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	930,649,742.63	1,195,576,228.15
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	676,832.00	-
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	929,972,910.63	1,195,576,228.15
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,383,000.00	28,024,137.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	1,383,000.00	300,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,383,000.00	300,000.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	-	27,724,137.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	27,706,767.00
213405	Нэмэлт санхүүжилтийн төвлөрүүлэх шилжүүлэг	-	17,370.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	1,467,743,389.37	1,654,648,067.85
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	1,467,743,389.37	1,654,648,067.85

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Тайланг хугацаа: 2021.12.31

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Бусад	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	4,362,183,848.38	1,922,631,447.55	1,082,710,680.34		7,367,525,976.27
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	2317144297 СНА0046 9074082	-
C03	Дахин нлэрхийлсэн үлдэгдэл	4,362,183,848.38	1,922,631,447.55	1,082,710,680.34	-	7,367,525,976.27
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	-	-	-	-	-
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	-	-	-	-	-
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-	-	-
C07	Тайланг үеийн үр дүн	-	-	1,467,743,389.37	-	1,467,743,389.37
C08	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	4,362,183,848.38	1,922,631,447.55	2,550,454,069.71	-	8,835,269,365.64
D01	2020 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	4,362,183,848.38	1,922,631,447.55	2,550,454,069.71	-	8,835,269,365.64
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-	-
D03	Дахин нлэрхийлсэн үлдэгдэл	4,362,183,848.38	1,922,631,447.55	2,550,454,069.71	-	8,835,269,365.64
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	-	-	-	-	-
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	-	-	-	-	-
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-	-	-
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	-	-	-	-	-
D08	Тайланг үеийн үр дүн	-	-	1,654,648,067.85	-	1,654,648,067.85
D09	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	4,362,183,848.38	1,922,631,447.55	4,205,102,137.56	-	10,489,917,433.49

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Тайланг хугацаа: 2021.12.31

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	970,563,006.00	1,214,624,604.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	970,563,006.00	1,214,624,604.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	158,311,900.00	437,253,300.00
131008	Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас санхүүжих	158,311,900.00	437,253,300.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	49,376,006.00	46,907,425,691,904.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарисан хөрөнгө	12,000,000.00	7,117,674.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	37,376,006.00	18,574,230.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	762,875,100.00	751,679,400.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	762,875,100.00	751,679,400.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	970,563,006.00	1,100,475,371.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	970,563,006.00	1,100,475,371.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	969,062,332.00	1,072,451,234.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	3,559,600.00	3,000,000.00
210102	Нэмэгдэл	3,559,600.00	-
210105	Гэрээт ажлын хөлс	-	3,000,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	934,000.00	5,000,000.00
210402	Тээвэр, шатахуун	934,000.00	5,000,000.00
2105	Нормативт зардал	6,120,000.00	-
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	6,120,000.00	-
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	33,584,900.00	14,115,234.00
210604	Урсгал засвар	33,584,900.00	14,115,234.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	924,187,000.00	1,050,336,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	924,187,000.00	1,050,336,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	676,832.00	-
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	676,832.00	-
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,500,674.00	28,024,137.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	1,383,000.00	300,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,383,000.00	300,000.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	117,674.00	27,724,137.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	117,674.00	27,706,767.00
213405	Нэмэлт санхүүжилтийн төвлөрүүлэх шилжүүлэг	-	17,370.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	-	114,149,233.00
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	-	61,855,000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	-	61,855,000.00
2200	Дотоод эх үүсвэрээр	-	61,855,000.00
223001	Бусад хөрөнгө	-	61,855,000.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	-	(61,855,000.00)
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	-	52,294,233.00
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	52,294,233.00

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Тайланг хугацаа: 2021.12.31

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайланг оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,188,932,700.00	1,108,931,700.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,188,932,700.00	1,108,931,700.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,188,932,700.00	1,108,931,700.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,188,932,700.00	1,108,931,700.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,188,932,700.00	1,108,931,700.00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	1,188,932,700.00	1,161,225,933.00
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	437,253,300.00	437,253,300.00
131008	Орон нутгийн хөгжлийн төгдсөн сангаас санхүүжих	437,253,300.00	437,253,300.00
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	751,679,400.00	723,972,633.00
132001	Орон нутгийн төсвөөс	751,679,400.00	723,972,633.00
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		-
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		52,294,233.00

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Тайланг хугацаа: 2021.12.31

Дансны код	Үзүүлэлт	Гүйцэтгэл	төгрөгөөр
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН		25,691,904.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ		25,691,904.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2317144	25,374,534.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	С/ДА0045 007	3,000,000.00
210105	Гэрээт ажлын хөлс		3,000,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал		5,000,000.00
210402	Тээвэр, шатахуун		5,000,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал		14,115,234.00
210604	Урсгал засвар		14,115,234.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж		3,259,300.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж		3,259,300.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ		300,000.00
2132	Бусад урсгал шилжүүлэг		300,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал		300,000.00
2133	Олгосон санхүүжилт, шилжүүлэг		17,370.00
213405	Нэмэлт санхүүжилтийн төвлөрүүлэх шилжүүлэг		17,370.00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР		25,691,904.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого		25,691,904.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө		7,117,674.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого		18,574,230.00

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Хэнтий аймгийн Хэрлэн сумын Өндөрхаан тохижилтын газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Хэнтий аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Б.Хуланхатан гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Д.Оюунтуяа, дарга, тэргүүлэх аудитор Ч.Эрдэнэбаатар нар тус тус хэрэгжүүлсэн.

Хэнтий аймгийн Хэрлэн сумын Өндөрхаан тохижилтын газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Хэнтий аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 01 дугаар сарын 27-ны өдрийн 06 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Хэнтий аймгийн Хэрлэн сумын Өндөрхаан тохижилтын газрын эрхэм зорилго нь “Хэрлэн сумын нийтийн эзэмшлийн гудамж талбайн цэвэрлэгээ, айл өрхийн хог хаягдлыг цуглуулж тээвэрлэх явц болон зам талбайн гэрэлтүүлэг, ногоон байгууламжийн арчилгаа, нийтийн тээвэр зэрэг чиглэлийн хүрээнд дэвшилтэт техник технологи ашиглан аймаг орон нутгийн газрын бодлого шийдвэрийг хэрэгжүүлэх, дээрх үйл ажиллагаанд хяналт тавин ЦЭВЭР ХОТ ХОТЫН СОЁЛ-ыг бий болгоход оршино” гэж тодорхойлжээ.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Хэнтий аймгийн Хэрлэн сумын Өндөрхаан тохижилтын газрын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Хэнтий аймгийн Санхүүгийн хяналт, дотоод аудитын алба нь дотоод аудитын чиг үүргийг хэрэгжүүлдэг ба Хэрлэн сумын Өндөрхаан тохижилтын газрын 2021 оны санхүүгийн үйл ажиллагаанд аудит гүйцэтгээгүй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудиторос шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ

илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Хэрлэн сумын Өндөрхаан тохижилтын газрын 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл “дунд” гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны жилийн эцсийн санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 1,818.1 сая төгрөгөөс 1 хувиар буюу 18.2 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 75 хувиар буюу 13.6 сая төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Хэнтий аймгийн Хэрлэн сумын Өндөрхаан тохижилтын газрын 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 1,636.3 сая төгрөгөөр өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан үндсэн хөрөнгийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	-	52.3	52.3
Авлага	0.1	-	(0.1)
Урьдчилгаа	-	-	-
Бараа материал	37.3	52.9	15.5
Үндсэн хөрөнгө	8,816.2	10,384.7	1,568.6
Нөөцийн бараа	-	-	-
Нийт хөрөнгө	8,853.6	10,489.9	1,636.3
Өр төлбөр	18.4	-	(18.4)
Засгийн газрын оролцоо	8,835.3	10,489.9	1,654.6
Засгийн газрын оролцоо/Өмч - Төрийн/	4,362.2	4,362.2	-
Өмнөх үеийн үр дүн	2,550.5	2,550.5	-
Тайлант үеийн үр дүн	-	1,654.6	1,654.6
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	1,922.6	1,922.6	-
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	8,853.6	10,489.9	1,636.3

Бараа материалын данс худалдаж авсан 304.1 сая, Аймгийн БОАЖГ -аас үнэ төлбөргүй хүлээн авсан 4.4 сая төгрөгийн материалаар нэмэгдэж, зарцуулсан 282.9 сая,

үндсэн хөрөнгө дансанд шилжүүлсэн 10.0 сая төгрөгийн хөрөнгөөр хасагдаж 52.9 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна.

Үндсэн хөрөнгө данс худалдаж авсан 61.8 сая, Аймгийн ОНХС-аас 1,943.7 сая, замын сангийн хөрөнгө оруулалтаар 349.9 сая, Аймгийн Орон нутгийн өмчийн газраас шилжүүлж авсан 0.8 сая, сумын ОНХС-аас 397.9 сая, бараа материал данснаас шилжүүлж авсан 10.0 сая, нийт үнэ төлбөргүй хүлээн авсан 2,702.3 сая төгрөгийн хөрөнгөөр нэмэгдэж, дуудлага худалдаагаар худалдсан тээврийн хэрэгслийн 29.8 сая төгрөгийн хөрөнгөөр хасагдсан байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 10,489.9 сая болж 1,654.6 сая төгрөгөөр буюу тайлант үеийн үр дүнгээр өссөн байна.

Санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого 625.3 сая төгрөгөөр буюу 19.0 хувиар өссөн нь өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан үнэ төлбөргүй хүлээн авсан орлого байна.

Нийт зардал өмнөх оноос 438.4 сая төгрөгөөр буюу 24.1 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамжийн зардал байна.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр болон нийт зарлагыг 1,269.8 сая төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс 80.9 сая төгрөгөөр бууруулж 1,188.9 сая төгрөгөөр баталсан байна.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 6 арга хэмжээг санхүүжүүлэх 1,188.9 сая төгрөгийн төсөв баталсныг Аймгийн орон нутгийн хөгжлийн сангаас 437.2 сая, орон нутгийн төсвөөс 751.7 сая төгрөгийг санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр Аймгийн орон нутгийн хөгжлийн сангаас 437.2 сая, орон нутгийн төсвөөс 751.7 сая, нийт 1,188.9 сая төгрөгийн орлогын бүрдүүлж урсгал үйл ажиллагаанд 1,108.9 сая төгрөгийг зарцуулж 27.7 сая төгрөгийг орон нутгийн төсөвт буцаан төвлөрүүлж 52.3 сая төгрөгийн үлдэгдэлтэй гарсан байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Дээд шатны төсвийн захирагчаас 7.1 сая, төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого 18.6 сая, нийт 25.7 сая төгрөгийн орлогыг бүрдүүлж зарцуулсан байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.7 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

3.7.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансанд мэдээлбэл зохих таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авалтын 286.6 сая төгрөгийн 24 гүйлгээг мэдээлээгүй, мэдээллийг хуулийн хугацаанд үнэн зөв мэдээлж байх гэсэн өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлээгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага хүргүүлэв.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцээгүй гэж дүгнэлээ.

3.8 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар 0.3 сая төгрөгийн 1 төлбөрийн акт тогтоогдож, 7.2 сая төгрөгийн 1 албан шаардлага, 98.8 сая төгрөгийн 2 зөвлөмж өгснөөс актыг төлбөрийг барагдуулж 1 албан шаардлага, 1 зөвлөмжийг хэрэгжүүлж, Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой 97.7 сая төгрөгийн 1 зөвлөмжийг биелүүлээгүй байна.

3.9 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Анхаарал татахуйц асуудал байхгүй байна.

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 396.9 сая төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 58.0 сая төгрөгийн 2 алдааг санхүүгийн тайланд залруулж, 52.3 сая төгрөгийн зөрчилд 1 төлбөрийн акт, 286.6 сая төгрөгийн зөрчилд 1 албан шаардлага хүргүүлж, алдаа зөрчлийг арилгах 1 зөвлөмж өглөө.

4.1. Залруулсан алдаа

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналын алдаатай дараах залруулгыг санхүүгийн тайланд тусгаж, баталгаажуулав. Үүнд:

1. Дуусаагүй үйлдвэрлэл дансанд бүртгэлтэй 10.0 сая төгрөгийн цэвэр усны байгууламжийг үндсэн хөрөнгө дансанд шилжүүлж бүртгэж залруулав.
2. Тээврийн хэрэгсэл дансанд 48.0 сая төгрөгийн хогийн бункер бүртгэснийг бусад үндсэн хөрөнгө дансанд бүртгэж санхүүгийн тайланд залруулав.

4.2. Зөвлөмж

Аудитаар алдаа зөрчлийг арилгах 1 зөвлөмж хүргүүлээ. Үүнд:

Төсөвт зардлыг тохирсон эдийн засгийн ангиллын дагуу төлөвлөж, гүйцэтгэлийг тайлагнаагүй. Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамжийн зардлаас бүх зардлыг гаргасан байна.

Шийдвэрлэсэн нь: Зөвлөмж өгөх.

Өгсөн зөвлөмж : Төсвийг тогтоосон ангиллын дагуу төлөвлөж, гүйцэтгэлийг хэрэгжүүлж, бүртгэн, тайлагнах.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 05 дугаар сарын 20 -ны өдрийн дотор ирүүлнэ үү.

4.3. Төлбөрийн акт

Аудитаар залруулагдаагүй 52.3 сая төгрөгийн зөрчилд 1 төлбөрийн акт тогтоолоо. Үүнд:

1. Батлагдсан төсвийн зарцуулагдаагүй үлдэгдэл 52.3 сая төгрөгийг холбогдох дансанд төвлөрүүлээгүй.

Шийдвэрлэсэн нь: Төлбөрийн акт тогтоов.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/сая төгрөгөөр/

Д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Санхүүгийн тайлангийн аудитын асуудал											
1	Хэрлэн сумын Өндөрхаан тохижилтын газар	4	110.3	2	58.0	1	52.3			1	0
Дүн		4	110.3	2	58.0	1	52.3			1	0
Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал											
1	Хэрлэн сумын Өндөрхаан тохижилтын газар	1	286.6					1	286.6		
Дүн		1	286.6					1	286.6		
Нийт дүн		5	396.9	2	58.0	1	52.3	1	286.6	1	0



ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АКТ

2022 оны 03 сарын 22 өдөр

Дугаар 21/А 2370452

ХЭА-2022/186/НА-СТА-Т.ЦЗ

Чингис хот

Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд Хэнтий аймгийн Хэрлэн сумын Өндөрхаан тохижилтын газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Батлагдсан төсвийн зарцуулагдаагүй үлдэгдэл 52.3 сая төгрөгийг холбогдох дансанд төвлөрүүлээгүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 43 дугаар зүйл. 43.5-д "Төсвийн захирагч нь энэ хуулийн 43.1.3, 43.1.5-д зааснаас бусад төсвийг хоёр төсвийн жил дамжуулан зарцуулахгүй", Засгийн газрын 2015 оны 24 дүгээр тогтоолын хавсралт "Төрийн сангийн үйл ажиллагааны журам" -ын 8.13.3 -д "Төсвийн байгууллагын зарцуулаагүй дансны үлдэгдлийг Төв төрийн сангаас хүргүүлсэн удирдамжийн дагуу татан төвлөрүүлнэ" гэж заасныг тус тус хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т "Шалгагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно.", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.3.8 -д "Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т заасан бусад нөхцөл байдал үүссэн" гэсэн заалтыг үндэслэн ТОГТООХ нь:

1. Төсөвт төвлөрүүлээгүй 52.3 сая төгрөгийг Хэрлэн сумын Төрийн сан банк дахь "Нэр заагдаагүй бусад орлого" 100181700955 тоот дансанд төвлөрүүлэх.
2. Актын биелэлтийг 2022 оны 04 дүгээр сарын 20-ны дотор аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэхийг Хэрлэн сумын Өндөрхаан тохижилтын газрын захирал О.Гомбобаатар, нягтлан бодогч Т.Болортуяа нарт хариуцуулав.

ТӨЛБӨРИЙН АКТ ТОГТООСОН:

АУДИТОР

АУДИТЫН МЕНЕЖЕР

Б.ХУЛАНХАТАН

Д.ОЮУНТУЯА



ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2022 оны 03 дугаар сарын 22

Дугаар 187/А 2370452
ХЭА-2022/186/НА СТА-ТШЗ

Чингис хот

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Хэнтий аймагийн Хэрлэн сумын Өндөрхаан тохижилтын газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Шилэн дансанд мэдээлбэл зохих таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авалтын 286.6 сая төгрөгийн 24 мэдээлээгүй, мэдээллийг хуулийн хугацаанд үнэн зөв мэдээлж байх гэсэн өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлээгүй байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.4-д "таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр, хаяг" гэсэн заалтыг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Иймд "Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 тушаалаар батлагдсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.10-д "аудитаар илэрсэн алдаа, зөрчил, түүнийг арилгахаар өгсөн зөвлөмжийг хугацаанд нь хэрэгжүүлээгүй бол" гэж заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Аудитаар илэрсэн зөрчлийг арилгаж, биелэлтийг 2022 оны 5 дугаар сарын 20-ны өдрийн дотор аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх.
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Хэрлэн сумын Өндөрхаан тохижилтын газрын захирал О.Гомбобаатар, нягтлан бодогч Т.Болортуяа нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АУДИТОР

АУДИТЫН МЕНЕЖЕР

Б.ХУЛАНХАТАН

Д.ОЮУНТУЯА

2317144297
СЮА0046 9074082